



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 арын 11 өдөр

Дугаар А/346

Номгон

「Кейсийн асуудалд шуурхай зөвлөн туслах үүрэг」
бүхий мэргэжлийн баг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.4.1, 16.4.2, 17 дугаар зүйлийн 17.2, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2023 оны 01 дүгээр “Дүрэм батлах тухай” тогтоолын хавсралтаар батлагдсан дүрмийн 3.7.3 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхдийн хүчирхийлэл, хүүхэд алга болох, онц ноцтой гэмт хэргийн золиос болох зэрэг тухайлсан кейсийн асуудалд шуурхай зөвлөн туслах үүрэг бүхий мэргэжлийн багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Мэргэжлийн багийн ахлагч:

Н.Мэндбаяр

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга

Гишүүд:

Б.Ганбаяр

Аймгийн Цагдаагийн газрын Хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Цагдаагийн дэслэгч

Г.Лхагва-Очир

Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга

Г.Чингис


Монголын хуульчдын холбооны гишүүн, Улсын өмгөөлөгч

Ж.Дуламсүрэн

Нийгмийн түншлэлийн сүлжээ ТББ-ын тэргүүн

2. Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн ээлжит хуралдааны тэмдэглэл, дүрэмд тусгасан чиг үүргийн хэрэгжилтийг ханган, үр дүнтэй зохион байгуулж, тайлан мэдээг цаг хугацаанд нь тайлагнаж ажиллахыг Мэргэжлийн баг (Н.Мэндбаяр)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

* 624010337